



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 дугаар сарын 21

№ 01/75

Улаанбаатар хот

САГ- 2018/93/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Багануур” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Багануур” ХК нь 2017 онд:

1. УБ хот руу ажлаар 1 өдөр яваад ирсэн ажилчдад 1 өдрийн томилолтын зардал олгож 7,848.000 /долоон сая найман зуун дөчин найман мянган/ төгрөгийг байгууллагын зардал болгосон нь тус газрын гүйцэтгэх захирлын 2012 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн Б/111 дүгээр тушаалаар “Албан томилолт олгох, дүгнэх журам”-ыг баталсан боловч уг журмаа мөрдөөгүй;
2. 2016 оны анхан шатны баримттай засварын ажил болон шагнал урамшууллын зардлын нийт 12,433.500.00 /арван хоёр сая дөрвөн зуун гучин гурван мянга таван зуун / төгрөгийг 2017 онд дараа тооцоогоор хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар” болно, 9.2.1-д “Санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д алдаа зөрчилд Төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. УБ хот руу ажлаар 1 өдөр яваад ирсэн ажилчдад 1 өдрийн томилолтын зардал олгосон 7,848.000/ долоон сая найман зуун дөчин найман мянган/ төгрөг, 2016 оны анхан шатны баримттай засварын ажил болон шагнал урамшууллын зардлын нийт 12,433.500 / арван хоёр сая дөрвөн зуун гучин гурван мянга таван зуун/ төгрөгийг 2017 онд дараа тооцоогоор хаасан нийт 20,281.500 /хорин сая хоёр зуун наян нэгэн мянга таван зуун/ төгрөгийн зөрчлийг арилгах,
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Номинчулуун ерөнхий нягтлан бодогч П.Эрдэнээ нарт хариуцуулав.

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Д.ЦЭГМИДДОРЖ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
“СҮЛД-АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
“БАГАНУУР” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Э.НОМИНЧУЛУУН

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 03 дугаар сарын 21

№ 01/45

Улаанбаатар хот

срл- 2018/93/СТА-ТӨБОНДАН

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Багануур” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Багануур” ХК нь 2017 онд ТУЗ-ийн гишүүдэд нийт 38,440.000/ гучин найман сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.1.1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон төрийн захиргааны албан хаагчийн нэг сарын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (нэг сарын)-г хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар тогтоох”-ыг Төрийн өмчийн хороонд чиглэл болгосныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д “...алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн гишүүдийн цалинд илүү олгосон 38,440.000 /гучин найман сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийг холбогдох хүмүүсээр гаргуулан төлүүлж, УАГ-ын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Багануур” ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун, ерөнхий нягтлан бодогч П.Эрдэнээ нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Д.ЦЭГМИДДОРЖ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

“СҮЛД-АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
АУДИТОР Ч.ГҮНДБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

“БАГАНУУР” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Э.НОМИНЧУЛУУН

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



Аудитын код: САГ-2018/93/СТА-Т БОН ААН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:
“Сүлд-Аудит” ХХК
Утас: 70118016, 99114056
Цахим хаяг: info@suld-audit.mn

Улаанбаатар хот



Агуулга	
1	Аудитын гэрчилгээ 0
2	Аудитын тайлан 1
2.1	Оршил..... 1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... 1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин 2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... 2
2.5	Дотоод хяналт..... 3
2.6	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга..... 3
2.7	Шилэн дансны мэдээлэл 4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар 4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл 4
2.9.1	Санхүүгийн тайлагналын талаар..... 4
2.9.2	Дараа тайлангийн талаар..... 4
2.9.3	Дансны авлагын талаар..... 4
2.9.4	Борлуулалтын орлогын талаар..... 5
2.9.5	ААНОАТ-ын тайлагналын талаар 5
2.9.6	Урт хугацаат зээлийн өглөгийн талаар 5
2.9.7	Тайлант жилийн өргөмжлөлийн талаар..... 6
2.9.8	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн талаар 6
2.9.9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний талаар 6
2.9.10	Худалдан авах ажиллагааны талаар 7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал..... 7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд 7
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл..... 8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... 8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:..... 8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл 8
3	Менежментийн захидал..... 9
1.	Санхүүгийн тайлагналын талаар 10
2.	Дараа тайлангийн талаар 11
3.	Дансны авлагын талаар 12
4.	ТУЗ-ийн цалингийн талаар 13
5.	Урт хугацаат зээлийн өглөгийн талаар 14
6.	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний талаар 15
7.	Худалдан авах ажиллагааны талаар..... 16

БАГАНУУР ХК-ИЙН ГЭЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НОМИНЧУЛУУН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Багануур ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хэлсэн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Багануур ХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтөлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

▯▯ рэг, хариуцлага

Багануур ХК нь Нягтлан бодох бортгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хэлсэн 3 вш-р с-н зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дгнэлт г-х нь трийн аудитын байгууллагын рэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БҮГД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Багануур ХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн аудитын тайланг Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн нэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар үргэлжлэх зөрчлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, тодруулгад, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд дараа тайлан, сэлбэг материалын үлдэгдэл, авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй, ААНОАТ-ын тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлангаарх үлдэгдэлтэй зөрхтэй тайлагнагдсан, орлогоо илүү тайлагнасан, тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнг буруу тайлагнасан, үндсэн хөрөнгийн дахин нэлгээний талаар, ТУЗ-ийн цалингийн зардлын талаар, Мөнгөн гүйлгээний тайлан, үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв тайлагнах зөрчлийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын өөшөт ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хөлээх зөрөг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Багануур ХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, төмөнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, төмөнд нийцүүлэн баталсан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх зорилготой.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын зорилго юм.

Багануур ХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудитыг 2018 оны 2 дугаар сарын 12-ноос 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Сүлд-Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Гэндбаяр, аудитор О.Уранчимэгийн баг, чанарын хяналтын мэргэжилтэн аудитор С.Лхагважав нар хэрэгжүүлж ажиллав.



Багануур ХК-ийн удирдлага 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 12-нд, бусад анхан шатны баримтаа 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 13/193 дугаар албан бичгээр “Сэлд-Аудит” ХХК-д ирүүлсэн.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ӨЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компани нь байгаль орчинд ээлтэй сөрөг нөлөөгүй, тэргүүний дэвшилтэт техник, технологийг ашиглан өйлдвэрлэлийн өйл ажиллагаа явуулж, хэрэглэгчдийг стандарт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангаж, хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн өр ашигтай бизнес эрхлэхийг өндсөн зорилго болгон дараах чиглэлийн өйл ажиллагаа явуулна. Өөнд:

1.Нөөрсний олборлолт, баяжуулалт, боловсруулалт, борлуулалт

2.Гадаад дотоод худалдаа

3.Өйлдвэрлэл, технологийн паркийн өйл ажиллагаа

Тухайн байгууллагатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Багануур ХК нь Ашигт малтмалын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ Сангийн сайдын 2014 оны 249, 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн өйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна. Багануур ХК нь дулааны станцуудыг нөөрсээр хангах зорилготой ажиллаж байна.

2.4 Аудитын шалгуур зөвлөлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, төний өрдөн


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хэлсэн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Багануур ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх өднөөс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн өндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг өнөлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого зарчмуудыг өнөлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад төвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 17 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын төвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар тооцож 2,543.6 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн өйл ажиллагааг бүртгэх, хянах боловсруулах өйл ажиллагааг “Даймонд” програмаар боловсруулан санхүүгийн тайланг бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.



2.5 Дотоод хяналт

ТУЗ-ийн 2014 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 25 дугаар тогтоолоор дотоод хяналтын албыг байгуулах шийдвэр гаргасан. Албаны зохион байгуулалтаар орон тооны 4 ажилтантай хэлтсийн удирдлагад ажиллаж байна. 2017 онд дотоод хяналтын төлөвлөгөөг 19 төрлийн ажил гүйцэтгэхээс 18 төрлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Биелээгүй ажил нь охин компанид тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Голдуу уурхайн үйл ажиллагаа талдаа анхаарч ажилласан байна. Компанийн дотоод хяналтын албаны ажилтай танилцаж, санал хүсэлтийг сонсож, зөвлөгөө өгсөн. Цаашид компанийн өр авлага, зардалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.6 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот төвшний талаарх тайлбар, тодруулга

Тус компани нь 2017 оны бизнес төлөвлөгөөг ТУЗ-ийн 2017 оны 01 дүгээр сарын 5-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулан ажилласан байна. Багануур ХК-ийн 2017 оны зөвхөн нөрсний орлогын гүйцэтгэл 124,860.0 сая төгрөг байгаа ба төлөвлөгөөт орлого нь 102.8%-иар биелсэн байна.

Багануур ХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт
зорилтот төвшнийг төлөвлөгөө гүйцэтгэл

/ сая төгрөг /

№	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны төлөвлөгөө	2017 оны гүйцэтгэл	Хувь	Зөрөө +/-
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт биетээр					
	Нөрс гаргалт	мян.тн	3,910.0	4,019.4	103%	109.4
	Нөрс борлуулалт	мян.тн	3,910.0	4,039.2	103%	129.2
	Хөрс хуулалт	мян.м3	19,000.0	21,054.9	111%	2,054.9
	Нийт уулын цул	мян.м3	30,979.2	33,644.6	109%	2,665.4
2	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нийн дүнгээр					
	Нийт орлого	сая төгрөг	123,369.4	127,182.5	103%	3,813.1
	Энэ: Цэвэр орлого	сая төгрөг	121,016.7	124,860.0	103%	3,843.3
3	Нийт зардал	сая төгрөг	121,923.9	126,022.8	103%	4,098.9
	Удирдлагын зардал	сая төгрөг	4,582.3	10,697.5	233%	6,115.2
4	ТТ А	сая төгрөг	1,445.5	512.9	35%	(932.5)
5	Цэвэр ашиг	сая төгрөг	1,294.4	461.6	36%	(832.8)
6	Орлогын татвар	сая төгрөг	51.0	51.3	100%	0.2
7	Ажиллагсдын тоо	тоо	1,123.0	1,120.0	100%	(3.0)
8	Цалингийн сан	сая төгрөг	32,819.9	32,797.4	100%	(22.5)
9	Авлага	сая төгрөг	6,267.9	7,249.2	116%	981.3
10	Өртөлбөр	сая төгрөг	144,813.4	157,966.5	109%	13,153.1
12	Хөрөнгө оруулалт	сая төгрөг	31,451.2	27,800.0	88%	(3,651.2)

Багануур ХК нь 2017 онд 3,910.0 мян.тн нөрс гаргаж, борлуулахаас 4,019.4 мян.тн нөрс гарган 103%-ийн гүйцэтгэлтэй, 19,000.0 мян.м3 хөрс хуулах төлөвлөгөөнөөс 21,054.9 мян.м3 хөрс хуулж, нийт 30,979.2 мян/м3 уулын цулын ажил гүйцэтгэхээс 33,644.6 мян/м3 уулын цулын ажил хийж төлөвлөгөөт зорилтоо 109%-иар биелүүлсэн байна. 2017 онд нийт 127,182.5 сая төгрөгийн орлоготой, 126,022.8 сая төгрөгийн зардалтай ажилласан.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.7 Шилэн дансны мэдээлэл

Багануур ХК нь 2017 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна. Тайлант онд Багануур ХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Компанийн “Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах журам” шинэчлэн баталж 6 төрлийн 61 мэдээлэл байршуулахаас 56 мэдээллийг хугацаанд нь байршуулж, тус компаний хувьд 5 төрлийн мэдээлэл нь оруулах мэдээлэл байгаагүй байна. Хугацаа хожимдуулсан буюу засвар оруулан байршуулсан мэдээлэл байхгүй байна.

2.8 Төлөвлөлийн шатанд тооцсон эрсдэл, төрлийн дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 55 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлийн хэрэгэнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн тайлагналын талаар

Интер-Актив Би Ай ХХК-ийн Даймонд 5.0 програм хангамжаар санхүүгийн тайлан тооцоогоо гаргадаг. Мөнгөн гүйлгээний тайлангаа буруу бэлтгэн тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэн гаргах заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэн, Санхүүгийн програмыг бүрэн гүйцэт хэрэглэж 2018 оны жилийн санхүүгийн тайлан болон тодруулгыг бэлтгэн гаргах, тайлагнах талаар зөвлөмж өгөх:

2.9.2 Дараа тайлангийн талаар

Дараа тайлангийн зардлын анхан шатны баримтыг төлөвлөн шалгахад: УБ хот руу ажлаар 1 дөрөв яваад ирсэн ажилчдад 1 өдрийн томилолтын зардал олгож 7.9 сая төгрөгийг байгууллагын зардал болгосон байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын 2012 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн Б/111 дүгээр тушаалаар “Албан томилолт олгох, дүгнэх журам”-ыг баталсан боловч уг журмаа мөрдөхгүй;


Томилолтын хугацаанд гүйцэтгэсэн ажлыг дүгнэдэггүй, томилолтын зардлын тооцоог ажлын 5 хоногийн дотор хийгээгүйгээс тайлант ондоо зардал нь тусгагдаагүй 2016 оны анхан шатны баримттай засварын ажил болон шагнал урамшууллын зардал зэрэг нийт 12.4 сая төгрөгийг 2017 онд дараа тооцоогоор хаасан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 10.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар” болно, 9.2.1-д “Санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг 20.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөх;

2.9.3 Дансны авлагын талаар

Тус байгууллагын 2017 оны жилийн эцсээр тайлагнагдсан 7249.2 сая төгрөгийн дансны авлагыг тооцооны өлдөгдлийн баталгаатай тулгахад 906.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.



Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж хяргүүлэх;

2.9.4 Борлуулалтын орлогын талаар

2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнасан нөрсний борлуулалтын орлого нь НАТ-ын тайлан, АМНАТ-ын орлогоос 251.2 сая төгрөгөөр зөрж байгаа нь замд яваа бэлэн бтээгдэхүүнийг шууд борлуулалтын орлогоор хуваан зөвшөөрч дансны буруу бичилт хийж борлуулалтын орлогоо 251.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаарх "Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт"-ыг мөрдөх зөвлөмж өгч зөрсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаарх "Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт"-ыг мөрдөх зөвлөмж өгч, аудитлагдсан санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2.9.5 ААНОАТ-ын тайлагналын талаар

2017 оны жилийн эцсээр тайлагнасан санхүүгийн тайлангийн нийт татварын өрийн үлдэгдэл 370.4 сая төгрөгөөр ААНОАТ-ын тайлангаарх үлдэгдлээс дутуу тайлагнагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4 "Хөрөнгийн тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах баримтжуулах" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4 "Хөрөнгийн тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах баримтжуулах" заалтыг мөрдөх зөвлөмж өгч аудитлагдсан санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2.9.6 Урт хугацаат зээлийн өглөгийн талаар

Тухайн байгууллагын 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүү байдлын тайлангаар урт хугацаат зээлийн өглөг 72,009.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Уг урт хугацаат зээлийн 52% буюу 37,729.8 сая төгрөгийн зээл нь 1997-2001 оны хооронд Монгол нөрс төслийн хэрээнд /МОГ2854, МОН-ПИ4/ Дэлхийн банк, Японы засгийн газраас СЯ-аар дамжуулан авсан зээл байна. Зээлийн үлдэгдэл 37,729.8 сая төгрөгийг СЯ-тай тооцоо нийлсэн ахуйн баталгаажуулсан байна. Багануур ХК-ийн өнцгийн санхүүгийн байдалд санхүүгийн тайлангийн хуримтлагдсан төлбөр сөрөгөөр нөлөөлж өрийн харьцаанууд алдагдсан

Шийдвэрлэсэн нь: Үр ба нийт хөрөнгийн зохистой харьцааг хангах олон жил хуримтлагдсан үр төлбөрийн асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх;

2.9.7 Тайлант жилийн үр дүнгийн талаар

Шивээ овоо ХК-иас авах авлагаас 2010, 2011 онуудын валютын зээл төгрөгт шилжсэн үеийн ханшийн зөрөө 94.2 сая төгрөгийг тайлант оны үр дүнд нөлөөлсөн.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны үдийн 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаарх “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-ыг мөрдөх зөвлөмж өгөх;

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны үдийн 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаарх “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт”-ыг мөрдөх зөвлөмж өгөх;

2.9.8 ТУЗ-ийн гишүүдийн цалингийн талаар

Тус байгууллага нь ТУЗ-ийн гишүүдийн цалинд 2017 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сар хүртэл нийт 38.4 сая төгрөг илүүлж олгосон байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын 2012 оны 7 дугаар сарын 06-ны үдийн Б/111 дугаар тушаалаар “Албан томилолт олгох, дүгнэх журам”-ыг баталсан боловч уг журмаа мөрдөхгүй.

Шийдвэрлэсэн нь: Уг 38.4 сая төгрөгийн зөрчилд акт тогтоох;

2.9.9 Үндсэн хөрөнгийн дахин нэлгээний талаар

Багануур ХК нь 2017 оны 7 дугаар сарын 27-ны үдийн 01/872 дугаар бүхий албан бичгээр үндсэн хөрөнгөд дахин нэлгээ хийлгэх хөсөлтийг СЯ-д хөрүүлснээр СЯ-аас 2017 оны 8 дугаар сарын 01-ний үдийн 7/4556 дугаар албан бичгээр үндсэн хөрөнгөд дахин нэлгээлэх талаарх асуудлаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан шийдвэрлэх нь зөйтэй гэсэн хариу өгсөн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2017 оны 10 дугаар 6-ны А-5/2711 дугаар албан бичгээр үндсэн хөрөнгөд дахин нэлгээ хийлгэж данс бүртгэлдээ тусгах нь зөйтэй гэсэн хариу ирүүлсэн байна.

ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 15-ны үдийн 33 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөд дахин нэлгээ хийлгүүлж санхүүгийн тайланд тусгах үүрэг өгсний дагуу үндсэн хөрөнгийн дахин нэлгээ хийгдсэн байна.


Үндсэн хөрөнгийн дахин нэлгээг “Хан нэлэмж” ХХК-иар хийлгэсэн байна. Тухайн байгууллагын данс бүртгэлд 93,230.9 сая төгрөгийн дансны нэ бүхий үндсэн хөрөнг бүртгэлтэй байсан. Дахин нэлгээгээр 50,108.7 сая төгрөг нэмэгдэж, 1,080.2 сая төгрөг бүрч, 142,259.5 сая төгрөгийн үндсэн хөрөнг данс бүртгэлд бүртгэгдсэн байна. Дахин нэлгээгээр 49,028.6 сая төгрөг үндсэн хөрөнг нэмэгдсэн байна. Нэлгээний тайланд аудит дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нэлгээний тайланд хөрөнгийн нэр төрлөөр цаашид ашиглах хугацааг тодорхойлсоноор хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцох хугацааг тогтоож ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулж, мөрдөхгүй.

Нэлгээний тайланд хөрөнгийн нэр төрлөөр НББОУС 36 “Нэ цэнийн бууралт”-д заасны дагуу дансны нэ болон нөхдөг дүнг тооцож данс бүртгэлд тусгаагүй.

Санхүүгийн тайланд хөрөнгийн нэр төрлөөр гаргасан анхны өртөг болон хуримтлагдсан элэгдлийн дүнг тусгаагүй.

Энэ нь үндсэн хөрөнгийн дахин нэлгээг данс бүртгэлд тусгахдаа НББОУС 16-н 36-г мөрдөхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: НББОУС16-н 36-д заасны дагуу нндсэн хрнгийн дахин нэлгээг данс бртгэлд тусгах талаар менежментийн захидлаар звлмж хрглэх;

2.9.10 Худалдан авах ажиллагааны талаар

Нийт худалдан авалтаас твэрлэн зэхэд нийт 5-н аж ахуйн нэгжтэй 111.1 сая тгрнгийн нндсэн хрнгийг, 112.5 сая тгрнгийн сэлбэг материалыг ямар ч сонгон шалгаруулалтгүйгээр нийт 223.6 сая тгрнгийн шууд худалдан авалт хийсэн байна.

